



Г ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД  
ДАРГА Б.ГАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.07.19 № 03/11961  
танаи -ны № -т

Г Зөвлөмж хүргүүлэх тухай Г

Нийтийн албан тушаалтны ёс зүйн байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авалтын болон зарим үндсэн үйл ажиллагааны авлигын эрсдэлийг тодорхойлох төрийн байгууллагаас гаргасан дүрэм, журамд дүн шинжилгээ хийх, хянан шалгах зорилгоор Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороонд АТГ-ын Ажлын хэсэг ажиллав.

Тус байгууллагын үйл ажиллагаанд авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч, хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 8 хуудастай.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

3.БААСАННЯМ



142303012345

Авлигатай тэмцэх газрын  
2023 оны 07 дугаар сарын 19.. -ны  
өдрийн ... дугаар албан 03/  
бичгийн хавсралт 14961

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

### ЗӨВЛӨМЖ

УХД0422 51200329

Зөвлөмж 1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, түүний үр ашигтай байдалд тавих хяналтыг сайжруулах, гэрээний гүйцэтгэлд дотоод болон хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх, үр дүнг тогтмол тооцож хөвшүүлэх, санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, буруутай албан тушаалтанд зохих хариуцлага тооцон, учирсан хохирлыг төлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Биеийн тамир, спортын улсын хороо нь жилийн нийт төсөв 110 орчим тэрбум төгрөг бөгөөд, үүнээс урсгал зардал болон үйл ажиллагааны үндсэн зардалд жилд 60-70 тэрбум, хөрөнгө оруулалт болон бусад зардалд 40-50 тэрбум төгрөгийн төсөв батлагдан зарцуулдаг. Урсгал зардал болон үйл ажиллагааны үндсэн төсвөөс Үндэсний шигшээ багийн зардалд жилд 10-20 тэрбум төгрөг, олимпын жилд түүнээс илүү хөрөнгийг зарцуулдаг байна.

Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, дотоод болон хөндлөнгийн хяналтын дүгнэлт, зөвлөмжийг бүрэн гүйцэт хэрэгжүүлдэггүй, холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй, санхүүгийн баримт бичиг бурдэл хангартгүй, зарим тохиолдолд анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн байж болзошгүй нөхцөл байдалтай байна. Тухайлбал,

Агентлагийн даргын зардал гаргах тухай А тушаалаар спорт, биеийн тамирын уралдаан тэмцээнд олон төрлийн санхүүжилт, зардлыг гаргадаг бөгөөд, тушаал гаргахдаа зарим албан тушаалтны гарын үсгийг дуурайж зурах, бусдын өмнөөс гарын үсэг зурах, ийм тушаалаар тодорхойгүй зардал гаргах, гарсан зардлын тайлан, баримтыг хуурамчаар үйлдэх, эсхүл арга хэмжээнд зарцуулалгүй төрийн бус байгууллагын дансаар дамжуулан гаргаж авсан байж болзошгүй тохиолдол цөөнгүй байна.

Урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ ажлын үр дүн, гүйцэтгэлийг харгалзалгүй ижил дүнтэйгээр нийт ажилтнуудад тусламж, урамшууллыг хавтгайруулан олгосноос гадна зуслангийн зориулалттай газар олгоходоо кадастрын зургийг төсвийн санхүүжилтээр өндөр үнийн дүнтэйгээр хийлгэжээ.

Ажилтнуудад урамшуулал, тусламж дэмжлэг олгох асуудлыг шийдвэрлэх тал дээр санаачилгатай ажиллаж байгаа боловч ажлын гүйцэтгэл, үр дүнд тавих хяналт сул, дотоод хяналт хийдэггүй нь учир дутагдалтай байна. Мөн тусламж дэмжлэг авсны дараа ажлаас чөлөөлөгдсөн тохиолдол цөөн бус байв.

Зөвлөмж 2. Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ил тод сонгон шалгаруулж, нээлттэй болгох; түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, түүнд тогтмол хяналт тавьж санхүүгийн аудит хийлгэх;

Төрийн өмч, төсвийн хөрөнгийг хувийн аж ахуйн нэгжид давуу байдал үүсгэн, урт хугацаанд үнэ төлбөргүй ашиглуулсан, хувийн хэвшилд давуу байдал бий болгосон байж болзошгүй үйлдлүүд байна. Тухайлбал, Спортын төв ордны байранд 4 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнд сонгон шалгаруулалт явуулалгүй, түрээс төлбөр авалгүйгээр төрийн өмчийн байрыг ашиглуулж байна.

Тус байрны гадна талын 48,3 сая төгрөгийн балансын үнэлгээ бүхий авто зогсоолыг нийслэлийн өмчлөлд 2008 онд шилжүүлсэн гэх боловч Ажлын хэсэгт холбогдох албан баримтыг ирүүлээгүй, уг газрыг аж ахуйн нэгжид төлбөртэй зогсоол

байдлаар ашиглуулахдаа Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 4/27 дугаар, 2011 оны 7/66 дугаар тогтоол (2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн нэмэлт өөрчлөлт)-оор баталсан “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”-ыг баримтлаагүй байна.

Байгууллагын болон салбарын хэмжээнд өмч хөрөнгийн ашиглалт, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй байна.

**Зөвлөмж 3. Төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааны бүх үе шатыг ил тод болгох, төлөвлөлтийг оновчтой хийж, нээлттэй сонгон шалгаруулалтад тулгуурлан зохион байгуулж хэвшүүлэх, үр дүн, зохион байгуулалтад тавих хяналтыг сайжруулах, цахим хэлбэрт шилжүүлэх;**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан захиалагчид хамаарах боловч төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, арга хэмжээ зохион байгуулахдаа хуульд зааснаар нээлттэй тендер сонгон шалгаруулалт явуулахгүйгээр шууд худалдан авалт хийх, худалдан авах ажлын жилийн төлөвлөгөөг боловсруулан батлахдаа цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалтын зардал зэрэг найман төрлийн ажил, үйлчилгээг төлөвлөж ирсэн нь хангальгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчиж, өндөр төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг аваадаа тушаалаар зардлыг хуваан гаргадаг асуудал байна.

**Зөвлөмж 4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 4 дүгээр Захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, төсвөөс санхүүжилт олгохоор гэрээ хийж байгаа спортын шигшээ баг, холбоодын үйл ажиллагаанд нээлттэй ил тод байдлыг хангуулах, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх, өнгөрсөн хугацаанд олгосон санхүүжилтэд санхүүгийн аудит хийлгэх, холбоодод төсвөөс санхүүжилт олгох үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийж хяналт, хариуцлагыг сайжруулах;**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 4 дүгээр захирамжаар баталсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/72 дугаартай “Гэрээ батлах тухай” тушаалыг гаргасан байх бөгөөд уг тушаалаар спортын холбоодтой байгуулах гэрээний загварыг баталж, гэрээ байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг Үндэсний шигшээ багийн хэрэгжилтийн хэлтэст үүрэг болгосон байна.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын дээрх А/72 дугаартай тушаалаар баталсан гэрээний агуулга нь Ерөнхий сайдын 2022 оны 4 дүгээр захирамжаар баталсан журмын агуулгатай зөрчилдсөн, журмын зохицуулалтаас давсан, өөрөөр зохицуулсан, зарим тохиолдолд давхардуулсан хэм хэмжээг тусгаж, хэрэгжүүлж байгаа нь учир дутагдалтай байна. Энэ нь бусдад давуу байдал олгох, төсвийн хөрөнгийг журамласнаас өөр үйл ажиллагаанд зарцуулах, завших, мөн хүнд суртал, чирэгдэл үүсгэх эрсдэлтэй байна.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/72 дугаар тушаалаар холбоодтой гэрээ байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг Үндэсний шигшээ багийн хэрэгжилтийн хэлтсийн дарга буюу нэг хүнд төвлөрүүлсэн нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байх тул чиг үүргийг хуваарилж, хөндлөнгийн хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, жил бүр спортын 24 холбоотой санхүүгийн дэмжлэг

үзүүлэх тухай гэрээ байгуулдаг бөгөөд, гэрээний дагуу их хэмжээний санхүүжилт (жилд дунджаар 10-20 тэрбум төгрөг)-ийг олгодог ч гэрээний гүйцэтгэл, санхүүгийн зарцуулалт ямар ч хяналтгүй, түүнчлэн гэрээний гүйцэтгэл гаргаж өгөөгүй холбоодод санхүүжилтийг нь үргэлжлүүлэн олгосоор байна.

Спортын холбоо тус бүртэй гэрээг байгуулж байгаа үнийн дүнг хэрхэн тооцсон үндэслэл, судалгаа, тооцоолол тодорхойгүй, хүлээгдэж буй үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт мөн тодорхой бус, хэрхэн гэрээ байгуулж, дүгнэж байгаа процесс нь ойлгомжгүй, цахим сан үүсээгүй байгаа нь Биеийн тамир, спортын улсын хорооноос уг үйл ажиллагаанд бодитой хяналт тавьж чадахгүй байгааг харуулж байна. Иймд өнгөрсөн хугацаанд Үндэсний шигшээ баг бүрдүүлэх спортын төрлүүдийн холбоодтой гэрээ байгуулж олгосон санхүүжилтэд санхүүгийн аудит хийлгэхийг зөвлөж байна.

Гэрээний дагуу олгож буй санхүүжилтийн болон гэрээний төслийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэхгүй, ямар тооцоо судалгаанд үндэслэн тухайн мөнгөн дүнг төсөвлөж байгаа нь тодорхойгүй бөгөөд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, гэрээний гүйцэтгэлд санхүүгийн баримтыг хурамчаар бүрдүүлэх, тамирчдад төсвийг олгохгүй дундаас нь завших, гадаад албан паспортыг албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж өөртөө болон бусдад авч өгөх зэрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдлүүд гарч байгааг таслан зогсоож, давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй байна. Энэ үйл ажиллагаанд авлигын эрсдэл өндөр байх тул процессын дахин инженерчлэл хийх шаардлагатай гэж дүгнэв.

Төсвөөс санхүүжилт авч байгаа спортын холбоодын үйл ажиллагаанд ил тод байдлын тодорхой шалгуур, гэрээний гүйцэтгэлийг хангаагүйгээс хүлээлгэх хариуцлага, хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тодорхой журамлах, олон улсын болон бусад эх үүсвэрээс хүлээн авсан санхүүжилт, дэмжлэг, эд хөрөнгийн хандив тэдгээрийн зарцуулалтыг олон нийтэд ил тод тайлагнах, хүлээлгэх хариуцлагын болон гомдол гаргах (шүгэл үлээх), хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй байна.

**Зөвлөмж 5. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу, ил тод нээлттэй зохион байгуулах, төрийн албаны чадахуйн (мерит) зарчмыг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоол, Ерөнхий сайдын мөн оны 39 дүгээр захирамжаар баталсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, тодорхойлсон стратегийн зорилт, чиг үүргийг тус хороо ханганд ажиллаж байгаа эсэхэд дүгнэлт хийх, зохих арга хэмжээг авах;**

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын тушаалаар 2022 онд 7 албан хаагчид зэрэг дэвийг ахиулан, 5 шинээр, 2023 онд 13 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан, 4 албан хаагчид шинээр олгосон бөгөөд тэдгээрийн зэрэг дэв олгохыг хүссэн өргөдөл, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээний дүнг үндэслэл болгон олгожээ. Биеийн тамир, спортын улсын хорооны удирдлага нь албан хаагчдын тангараг өргөх тухай өргөдлийг шийдвэрлэж, 2020-2023 онд 7 албан хаагч тангараг өргөжээ.

Дээрх шийдвэрт дүн шинжилгээ хийхэд Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-д "тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албананд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албананд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх" гэсэн заалтыг тухай бүр мөрдөөгүй байна.

Төрийн албан хаагчийн зэрэг дэв олгох болон тангараг өргүүлэх үйл ажиллагаа тус бүрийг тухайн албан хаагч өргөдөл гаргаснаар шийдвэрлэсэн боловч түүнтэй холбоотой хурлын тэмдэглэл, баримт байхгүй байв.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2020 оны А/120 дугаар тушаалаар "Даргын зөвлөлийн ажиллах журам"-ыг баталснаас хойш хэлэлцсэн асуудлын 70 гаруй хувьд тайлан, мэдээллийг танилцуулсан, 10 хүрэхгүй хувьд бодлого үйл ажиллагаатай холбоотой 2 журмын тесэл болон цаг үеийн асуудлыг хэлэлцсэн боловч салбарын бодлого, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудлаар шийдвэр гаргаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 47 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороог байгуулж, орон тооны дээд хязгаарыг 72 байхаар тогтоожээ. Төрийн албаны зөвлөлд 2022-2023 онд нийт 43 албан тушаалын сул орон тоог нөхөн захиалгыг 6 албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ТАЗ-ийн тогтоолоор нэр дэвшилсэн 13 албан хаагч, 2022 онд төрийн захиргааны 19, үйлчилгээний 6 ажилтныг тус тус томилжээ.

Тус хороо нь дунджаар 48 албан хаагч (төрийн захиргааны 37, үйлчилгээний 11)-тай ажиллаж ирсэн нь нийт орон тооны 66,7 орчим хувь байжээ. Хэдийгээр орон тооны дээд хязгаар 72 байгаа боловч 43 ажилтан ажилласаар ирсэнд дүн шинжилгээ хийх нь зүйтэй байна.

Биеийн тамир, спортын улсын хороонд 2022-2023 онд 40 хувийн цалингийн нэмэгдэлтэй түр орлон гүйцэтгэсэн 11 хүн байсан ба одоо ажил хавсарч байгаа төрийн албан хаагч, үйлчилгээний ажилтан тус бүр 2 байна.

Тус агентлагийн албан тушаалын тодорхойлолт, ажлын гүйцэтгэл, түүнд үнэлгээ хийсэн байдалд ажлын хэсгээс түүврийн аргаар сонгон дүн шинжилгээ хийхэд нийтлэг илэрсэн зөрчил дутагдал нь бодлогын болон хэрэгжилтийн нэгжийн ажил, үүргийг нарийн зааглаагүй, албан тушаалын зорилго, зорилт, гүйцэтгэх үүрэг нь нэг адил агуулгатай, давхардал үүссэн, хуульд зааснаас доогуур шалгуур, шаардлага тавьсан, мэргэжлийн шалгуурыг зөвхөн спорт, биеийн тамирын мэргэжлээр нийтлэг байдлаар хязгаарласан, мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, үр дүнг бодитой үнэлдэггүй, ажлын гүйцэтгэл хангалтгүй ажилтнуудыг ч ялгалгүй хавтгайруулан улирал тутам урамшуулал тогтмол олгодог, ажлын цаг ашиглалтад хяналт тавьдаггүй, тасалсан, хоцорсон тохиолдол бүрд хариуцлага тооцдоггүй зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

Эдгээр зөрчлийг таслан зогсоох, буруутай албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож, байгууллагын дотоод шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Зөвлөмж 6.** Байгууллагын албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавих, ажлын байрны шинжилгээ хийлгэж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээнд хөндлөнгийн аудит хийлгэх, давуу байдал бий болгооос урьдчилан сэргийлэх;

Агентлагийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт хангалтгүй, түүнд тавих хяналт сул, нарийн журамлаагүй, цахим бүртгэл нь бүрэн ажиллаагүй, мөн зарим албан хаагчдад олон дахин чөлөө олгох, сургалтын төлбөр болон бусад дэмжлэг тусламжид тогтмол хамруулдаг бөгөөд ажлын гүйцэтгэл, цаг ашиглалтад удирдлагын тавих хяналт байхгүй байна.

**Зөвлөмж 7.** Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, авлига, ашиг сонирхлын зөрчилд хариуцлага хүлээлгэх, тавих хяналтыг сайжруулж, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч үр дүнг тооцох;

Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ерөнхий нягтлан бодогчийн бэр нь тус хэлтсийн тооцооны нягтлан бодогч, төрсөн охин нь Спортын анагаах ухааны эрдэм шинжилгээний төвд музейн харгалзагч, бичиг хэргийн ажилтан, мөн Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг гүйцэтгэж байсан ажилтан нь Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын бэр,

Бодлого төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Ёс зүйн хорооны дарга, Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга нар нь хамтран амьдрагч буюу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.11-т заасан нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Агентлагийн даргын зөвлөл хамтын шийдвэр гаргадаг бөгөөд Бодлого төлөвлөлтийн газрын дарга болон Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга нар тус зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

Түүнчлэн хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтээ энэ талаар мэдүүлээгүй, мөн ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаар мэдэгдэл, тайлбар гаргаж байгаагүй байна.

Дээрх хамаарал бүхий этгээдүүд нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 8.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 23 дугаар зүйлийн 23.2 дугаар хэсэгт заасныг хэрэгжүүлээгүй гэж үзэхээр байна.

Агентлагийн 4 албан хаагч хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлээгүй, хоцроосон, 3 албан хаагч хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулалгүй томилогджээ.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ХЭГ/595 дугаартай албан бичгээр Засгийн газрын нийт агентлаг, байгууллагын дарга наарт “Шүүр” ажиллагааны хүрээнд авах арга хэмжээний талаар хүргүүлсэн чиглэлийг тус агентлагийн хувьд хангалтгүй хэрэгжүүлжээ гэж дүгнэхээр байна.

Иймд тус агентлагт авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчил тогтоогдвол хариуцлага хүлээлгэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Зөвлөмж 8. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хуульд тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

Биеийн тамир спортын улсын хорооны Ёс зүйн хороо нь 2022, 2023 онуудад 2 удаа ёс зүйн хариуцлагатай холбоотой хурал хийж, 6 албан хаагчийн ёс зүйн асуудлыг хэлэлцэж, 3 албан хаагчид сануулах ёс зүйн хариуцлага тооцсон байна.

Ёс зүйн хорооны ажиллах журамтай танилцахад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Биеийн тамир спортын улсын хорооны даргын А/07 дугаар “Ёс зүйн хороо байгуулах тухай” тушаал гэсэн 2 өөр тушаалтай ба ёс зүйн хорооны гишүүдийн тоо, нэрс зөрүүтэй боловч адилхан огноо дугаартай бичгийн хэв, бүртгэлийн дугаар зөрүүтэй, албажуулсан удирдах албан тушаалтны гарын үсэг өөр, нэг тушаал нь 1 хавсралт, нөгөө нь 2 хавсралттай байна.

Ёс зүйн хорооны үйл ажиллагаатай танилцахад журмаа мөрдлөг болгон хэрэгжүүлдэггүй, ёс зүйн хороо байгуулсан тушаал нь хүчинтэй эсэх нь эргэлзээтэй, мөн ёс зүйн хорооны үйл ажиллагаа нь ил тод бус, ялгамжтай ханддаг зэрэг гомдол санал гарч байв.

Ёс зүйн хороо нь үйл ажиллагаандаа холбогдох журмаа баримталдаггүй, ил тод ажилладаггүй, шийдвэрээ журамд заасан хугацаанд нь танилцуулдаггүй, хуралдаанд оролцох эрхийг хангаагүй, ёс зүйн асуудлаар гомдол гаргагч нь тодорхойгүй гэдэг үндэслэлээр хэлэлцээгүй, хариуцлага тооцоогүй орхигдуулсан тохиолдол байна.

Тухайлбал, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга О.Гархи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ ажлын байран дээр танхайрч, байгууллагын эд хогшил эвдэн сүйтгэсэн, хамгаалалтын ажилтны биед халдсан зэрэг зүй бус үйлдэл гаргасан боловч ёс зүйн хариуцлага (шүүхийн шийдвэрээр ажилд нь эргүүлэн тогтоосон) хүлээлгээгүй; мөн Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ерөнхий нягтлан бодогч А.Ө ажлын байран дээр архидан согтуурч, ажил тасалсан, зүй бус үйлдэл гаргасан гэх гомдлыг хэлэлцээгүй, хаасан байв.

**Зөвлөмж 9.** Албан гадаад паспортыг тамирчин, дасгалжуулагч наарт олгох үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт үнэлгээ хийж, холбогдох журмыг зөрчсөн тохиолдлуудад хариуцлага хүлээлгэх, цаашид албан гадаад паспортыг үндэслэл журмын дагуу олгож буй эсэхэд тавих хяналтыг сайжруулах;

Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмын 3.4.1-т “дипломат, албан гадаад паспорт олгох үндэслэлийг тодорхойлсон энэ журмын 3.7-д заасан байгууллагын албан бичиг” гэж заасныг үндэслэл болгон Биеийн тамир, спортын улсын хорооноос тухай бүр албан паспорт олгуулах тухай хүсэлтийг холбогдох яаманд хүрүүлж байжээ.

Дээрх журмын 3.7.4-т “энэ журмын 3.7.3-т зааснаас Засгийн газрын бусад агентлаг харьялагдах төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргаар уламжилна” гэсэн заалтыг мөрдөөгүй байна. Тус байгууллага нь Монгол Улсын Үндэсний шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчдыг 2020 онд нэг удаа сонгон шалгаруулалт зарлаж албан ёсоор баталгаажуулжээ. Гэтэл түүнээс хойш уг жагсаалтад тус хороо нэмэлт оруулаагүй бөгөөд шигшээ багуудаас нэмэлт өөрчлөлт оруулан, улмаар албан паспорт хүссэн албан бичгийг тус хороо холбогдох яам руу илгээдэг болсон байна.

Гэвч тамирчин, дасгалжуулагч биш иргэдэд болон тус хорооны ажилтнууд албан үүрэг гүйцэтгэх, удирдамж, урилга байхгүй үед паспорт олгох тухай хүсэлтийг яаманд хүрүүлж, давуу байдал олгосон байж болзошгүй тохиолдол хэд хэд гарчээ. Байгууллагын 22 албан хаагч албан гадаад паспорт авсан нь нийт ажилтнуудын 40 гаруй хувь байх ба тэдгээрийн тухай судалгаа байхгүй, ашиглалтад тавих хяналт сүл байв.

Иймд Монгол Улсын дипломат, албан паспорт олгох, эзэмших, хадгалах журмын 5.3-т “Дипломат, албан гадаад паспорт мэдүүлэхдээ мэдүүлэгч нь баримт бичиг хуурамчаар үйлдсэн, худал мэдээлэл өгсөн, паспортаа бусдад ашиглуулсан, худалдсан, барьцаалсан асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

**Зөвлөмж 10.** Спортын цол, шагнал, зэрэг дэв олгох, бүртгэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангуулж, цахим хэлбэрт шилжүүлэх;

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны А/241 дугаар тушаалаар шагнал авсан иргэдийн мэдээлэл болон ажлын хэсгээс тулгасан мэдээлэл нь зөрүүтэй байв. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/120 дугаар зардал гаргасан тушаал дээрх нэрс хоорондоо зөрүүтэй зохих журмын дагуу шагнал олгосон эсэх нь тодорхойгүй бөгөөд холбогдох материал, бичиг баримт байхгүй 465 иргэнд шагнал, цол олгосон байж магадгүй байна.

Өөрөөр хэлбэл, болзол шаардлага хангаагүй этгээдэд спортын цол, шагнал, зэрэг дэв олгож, түүнийг дагасан давуу байдал бий болгох эрсдэлийг таслан зогсоох, цол, шагнал олгосон шийдвэр болон уг үйл ажиллагаанд аудит хийлгэж, зөрчлийг

арилгах, цаашид цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, олгох бүртгэлийн цахим санг бүрдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах нь зүйтэй.

**Зөвлөмж 11.** Спортын салбарын цахим системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологи, тоног төхөөрөмж хариуцсан нэгжийн үйл ажиллагааг журамлах, хяналтыг сайжруулах;

Салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээг 2018-2019 онд, салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн программ хангамжийн ажил 2020-2021 онд хийгдэж эхэлжээ.

Салбарын мэдээллийн нэгдсэн систем нь спортын тэмцээн, наадмын, спортын цол, статистик, бие бялдрын түвшин тогтоох сорил, шигшээ багийн, допингийн мэдээлэл, салбар төрийн байгууллагын цахим хуудас, спортын холбоодын гэсэн дэд системээс бүрдэхээр санхүүжилт авсан байна. Гэвч нэгдсэн цахим сангийн үйл ажиллагаа жигдрээгүй "И-Монголия" системтэй холбогдоогүй, улсын хэмжээнд спортын газартай цахим систем үүсгэн, холбогдоогүй, өгөгдөл нь боловсруулалт автоматжаагүй, хоорондоо уялдаагүй, одоо зохион байгууллагдаж байгаа томоохон тэмцээнүүдийн мэдээллийг бүртгэлд тус хорооны ажилтнууд ажиллаж өөрсдөө мэдээллийг оруулж, өгөгдөл үүсгэх байдлаар гүйцэтгэж байгаа бөгөөд төсвөөс хөгжүүлэлтэд санхүүжилт гарсаар байна.

Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын дагуу Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг үйл ажиллагаанд ашиглах, хамгаалах журам, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг батлан мөрдөөгүй, нууц хамгаалах ажилтан байхгүй байна.

Дээрх асуудал нь Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д "төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх" гэсэн заалтын хэрэгжилт бүрэн хангагдах нөхцөлийг бүрдүүлээгүй гэж үзэхээр байгаа учир холбогдох байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэж, зохих арга хэмжээг авах, биенийн тамир, спортын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд үнэлгээ өгөх боломжтой өгөгдлийн сан үүсгэх хэмжээнд хөгжүүлэлтийг хийх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах нь зүйтэй байна.

**Зөвлөмж 12.** Өргөдөл, гомдолын шийдвэрлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, шийдвэрлэлт дүн шинжилгээ хийж хэвших, архив албан бичгийн стандарт, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, архивын баримт бичгийг цэгцлэх арга хэмжээ авах;

Тус хороонд ирсэн 2022 оны өргөдлийн 60 буюу 58.0 хувь, 2023 оны 28 буюу 58.8 хувь нь иргэдийнх, 2022 оны гомдолын 83 нь ажилтных байх бөгөөд үүнээс 15 буюу 18.07 хувь нь ажлаас чөлөө хүссэн, 2023 оны хувьд 40 нь ажилтнаас гаргасан өргөдөл байх ба үүний 17 буюу 42.5 хувь нь ажлаас чөлөө хүссэн өргөдөл байна. Өргөдөл, гомдол хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлэх, тайлагнах, хариуг өгөх үйл ажиллагааг нарийвчлан журамлаагүй, архивын бичиг баримтын бүрдүүлбэр ханган баримтжуулаагүй (цахим санд шууд тайлбар бичиж хаасан) байна.

Мөн тус хорооны архивын өрөө нь төрийн байгууллагын архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалтын шаардлага, стандартыг хангаагүй, улсын Үндэсний шигшээ багуудтай байгуулсан 2022 оны гэрээ, түүнд холбогдох баримтыг хариуцсан ажилтан архивын нэгж үүсгэн хүлээлгэж өгөөгүй, 2021-2023 онд ирсэн, явсан бичиг, өргөдөл, гомдол болон бусад баримтыг архивлаагүй, удирдлагаас тухайн жилд архивлах баримтын жагсаалт гаргаагүй, түүнийг хариуцах албан хаагчийг тодорхойлоогүй, уг

үйл ажиллагаанд нэгжийн дарга, удирдлага зохих хяналтыг тавиагүй учраас он дамжсан архивлах баримт хуримтлагджээ.

Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын цахим системд тус агентлаг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр нэгдсэн ба уг программын хурдыг нэмэгдүүлэх, ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдлын тайланг татаж авах, албан хаагч бүр цахимд холбогдох мэдээллийг оруулах боломжтой байхаар хөгжүүлэлт хийх, мөн байгууллагын дотоод мэдээлэл солилцоог сайжруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Зөвлөмж 13. Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг чадавхжуулах, дотоод шалгалтын журам боловсруулж мөрдөх, мэргэжил арга зүйгээр хангах, мэргэжилтнүүдийг сургах, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг удирдлагын хурлаар хэлэлцүүлэх, орон нутгийн салбаруудад гарч буй нийтлэг зөрчил, эрсдэлийг арилгах чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, үр дүнг үнэлж хэвшүүлэх;

Байгууллагын хяналт-шинжилгээ дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр нөлөө сул байна. Нэгжийн зүгээс дотоод аудит, нийцлийн хяналтыг Улсын хороо болон түүний орон нутгийн хэд хэдэн салбарууд хийж, тайлан гаргасан боловч өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй, хэрэгжилтэд эргэн хяналт тавьдаггүй нь учир дутагдалтай байна. Тухайлбал, Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагаанд 2022 оны 02 дугаар сарын 17-28-ны хугацаанд нийцлийн аудит, мөн 2022 онд Агентлагийн даргын зөвлөлийн холбогдох баримтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан боловч өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, холбогдох нэгжүүдэд танилцуулаагүй, зөвлөмжид дурдсан зөрчил дутагдал хэвээрээ, холбогдох ажилтанд хариуцлага тооцоогүй байв.

Түүнчлэн тус хорооны 2021 оны үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудит (2022.02.17-28)-ын тайланд 5 бүлэг, 10 зөрчил дутагдал илэрсэн боловч дүгнэлт нь зөвхөн Спортын төв ордны барилга ашиглалтын шаардлага хангахгүй болсон байгаа талаар дүгнээд, зөвлөмж өгсөн байх бөгөөд эдгээр зөвлөмж нь хэт ерөнхий, биелэлт үр дүн тооцоход төвөгтэй байв.

Орон нутгийн салбарууд хийгдсэн дотоод аудитын тайланд төсөв, санхүү, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлэлт, гэрээ байгуулах, түүний биелэлтэд тавих хяналт сул зэрэг зөрчил дутагдал нийтлэг гарч байгааг дурдсан байхад салбарын хэмжээнд эдгээр зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг нэгдсэн байдлаар авч хэрэгжүүлээгүй байна.

Хяналт-шинжилгээ, дотоод аудит хариуцсан ажилтнуудыг сургах, чадавхжуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй, мэргэшүүлэх сургалтад хамруулахгүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

---000---